



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/133

Рашаант

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд
хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайхуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.7, 27 дугаар зүйлийн 27.5.2 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 15.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд А/220, Боловсрол шинжлэх ухааны сайдын А/475, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/812 тушаалын хэрэгжилтийг хангаж, сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: С.Аманкелд Засаг даргын тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Х.Ертай насан туршийн боловсрол хариуцсан багш

Гишүүд: Ш.Гүлжан Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гүлсайра эрүүл мэндийн нийгмийн ажилтан

М.Роза ЕБ-ын 1-р сургуулийн захирал

Е.Айнур ЕБ-ын 2-р сургуулийн захирал

М.Нурбек ЕБ-ын 3-р сургуулийн захирал

Х.Амангүл хүүхдийн 1-р цэцэрлэгийн эрхлэгч

М.Алтынай хүүхдийн 2-р цэцэрлэгийн эрхлэгч

А.Жанболат эцэг эх, асран хамгааллын төлөөлөл

Ш.Ферм эцэг эх, асран хамгааллын төлөөлөл

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан тус сумын ЕБ сургууль, цэцэрлэгт “Дэмжлэг баг”-ийг байгуулан ажиллуулахыг захирал эрхлэгч нарт даалгасугай.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамруулах ажлын нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж үйл ажиллагааг зардлын тухай жилийн төсөвт тусгуулан ажиллахыг зөвлөлийн дарга /С.Аманкелд/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.СЕРИКБОЛ

